

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН 2026
ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ТАНИЛЦУУЛГА**

АГУУЛГА

БҮЛЭГ 1. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ЧИГ ХАНДЛАГА	2
1.1. Худалдааны дайн намжсан ч дэлхийн эдийн засгийн төлөв байдал сул хэвээр байна.....	2
1.2. Голлох түүхий эдүүдийн үнийн хэлбэлзэл өндөр байна.....	3
1.3. Монгол Улсын эдийн засгийн төлөв байдал.....	5
БҮЛЭГ 2. МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН БОДЛОГО	7
2.1. БОДЛОГЫН 3 ЗОРИЛТ	8
2.2. БОДЛОГЫН 9 ЧИГЛЭЛ	9
БҮЛЭГ 3. МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ.....	14
БҮЛЭГ 4. ТӨСВИЙН ЭРСДЭЛ.....	15
БҮЛЭГ 5. ТӨСВИЙН ТУСГАЙ ШААРДЛАГА.....	18

БҮЛЭГ 1. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ЧИГ ХАНДЛАГА

1.1. Худалдааны дайн намжсан ч дэлхийн эдийн засгийн төлөв байдал сул хэвээр байна.

Сүүлийн саруудад АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп улс орнуудтай хэлэлцээр хийж тарифын бодлогоо сулруулж эхэлснээр худалдааны дайны эрсдэл намжиж эхэллээ. Үүнтэй зэрэгцэн олон улсын байгууллагууд дэлхийн эдийн засгийн өсөлтийн төлөв байдлыг өмнөх төсөөллөөс сайжруулсан. Тухайлбал, Олон Улсын

Зураг 1. Эдийн засгийн өсөлтийн хувь



Эх сурвалж: ОУВС-н төлөв байдлын 6-р сарын тайлан

Валютын Сан худалдааны эргэлт тогтворжиж, хөрөнгө оруулалтын урсгал нэмэгдэхээр тооцож 2025-2026 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийн төлөв байдлыг өмнөх төсөөллөөс 0.1-0.2 нэгж хувиар нэмэгдүүлэв. Худалдааны

хэлэлцээрүүд богино хугацаанд зах зээлд эерэг дохио өгч байгаа ч дунд, урт хугацаанд тогтворжих эсэх нь тодорхой бус хэвээр байна. Иймд, 2025–2026 оны дэлхийн эдийн засгийн өсөлт сүүлийн арван жилийн дунджаас доогуур түвшинд хадгалагдах хүлээлттэй байна. Энэ нөхцөлд улс орнууд эрсдэлд тэсвэртэй байдлаа нэмэгдүүлж, худалдааны шинэ түншлэлийг өргөжүүлэх, мөн дотоодын эрэлт ба хөрөнгө оруулалтыг дэмжихэд чиглэсэн бодлого хэрэгжүүлэх төлөвтэй байна. Зүүн Азийн хөгжиж буй орнууд худалдааны шинэ түншлэлийг эрэлхийлж, гадаад худалдааг нэмэгдүүлэх бодлого баримталж байгаа бол Латин Америкийн орнууд уул уурхайн салбараас өндөр хамааралтай байдлыг бууруулж, эдийн засгийн төрөлжилтийг нэмэгдүүлэх чиглэлд голлон анхаарч байна.

БНХАУ-ын эдийн засаг 2025 оны эхний хагас жилд 5.3 хувиар өсөж, хүлээлтийг давлаа. Өсөлтөд АНУ-аас гадна бусад улс орнууд руу чиглэсэн экспорт нэмэгдсэн нь голлон нөлөөлж, нийт экспортын хэмжээ 7.2 хувиар өсөв. Харин импорт 2.7 хувиар буурсан нь зарим төрлийн түүхий эдийн эрэлт буурч, дотоодын хөрөнгө оруулалтын идэвх суларсныг илтгэнэ. Салбарын хувьд аялал жуулчлал, цахим худалдаа зэрэг үйлчилгээний салбар эерэг өсөлт үзүүлсэн бол үл хөдлөх хөрөнгийн салбарын хөрөнгө оруулалт 11.0 хувиар буурч, уналт үргэлжилсэн хэвээр байна. Мөн инфляц 0 орчим хувь байгаа нь дотоодын хэрэглээ бүрэн сэргээгүйг харуулж байна.

Fitch Rating агентлагийн үзэж байгаагаар, БНХАУ-ын эдийн засгийн өсөлт нь төсвийн тэлэлт зэрэг Засгийн газрын бодлогын дэмжлэг болон тариф хэрэгжихээс өмнөх экспортын захиалгыг түрүүлж гүйцэтгэсэн "front-loading" үйл явцад тулгуурласан, түр зуурын шинжтэй өсөлт байх магадлалтай гэж үзэж байна.¹ Мөн сүүлийн саруудад АНУ-ын гадаад худалдааны тарифын бодлого харьцангуй зөөлөрснөөс шалтгаалан Олон улсын валютын сан БНХАУ-ын 2025 оны өсөлтийн төлөвийг 4.8 хувь, Дэлхийн банк 4.6 хувь болгон өсгөсөн ч, 2026 онд уг үзүүлэлт ОУВС-ын тооцоогоор 4.2 хувь, Дэлхийн

¹ China's Port Throughput Slows Further, but Offset by Front-Loading Containers

банкны таамгаар 4.0 хувь болж буурахаар тооцоолжээ. Энэ нь үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн удаашрал, дотоодын хөрөнгө оруулалтын идэвх сул, мөн гадаад худалдааны орчны тодорхойгүй байдалтай холбоотой гэж үзэж байна.


БНХАУ-ын 2021–2025 оны 14 дэх “Таван жилийн төлөвлөгөө”-ний хүрээнд үл хөдлөх хөрөнгө, барилга байгууламж болон хүнд үйлдвэрлэлд тулгуурласан, хурдтай өсөлтийн загварыг баримталж ирсэн бол 2026–2030 оны 15 дахь “Таван жилийн төлөвлөгөө”-нд шинжлэх ухаан, дэвшилтэт техник, технологид суурилсан шинэ бүтцийг төлөвшүүлж, эдийн засгийн чанартай өсөлтөд чиглэсэн бодлого давамгайлах төлөвтэй байна. Үүнтэй уялдуулан өндөр технологийн үйлдвэрлэл, ногоон эрчим хүч, дижитал эдийн засаг, хиймэл оюун ухаан, биотехнологи зэрэг стратегийн ач холбогдол бүхий салбаруудыг эрчимтэй хөгжүүлж, инновацын экосистемийг өргөжүүлэх зорилтыг тэргүүлэх чиглэл болгохыг Шанхай хотноо болсон уулзалтын үеэр БНХАУ-ын улсын Ерөнхийлөгч Ши Жиньпин онцлон тэмдэглэсэн байна.²

Мөн гадаад бодлогын хүрээнд АНУ болон хөгжингүй орнуудаас эдийн засгийн хараат байдлаа бууруулахын зэрэгцээ “Дэлхийн Өмнөд”-ийн орнуудтай дэд бүтэц, аж үйлдвэржилтийн салбарт хамтын ажиллагааг идэвхжүүлэх бодлого баримталж байна. Сингапурын Үндэсний их сургуулийн дэд профессор Гү Чиньянгийн тайлбарласнаар, Дэлхийн Өмнөдийн дэд бүтэц, аж үйлдвэржилтийн эрэлт хэрэгцээг хангаж, эцсийн хэрэглээний барааны оронд аж үйлдвэрийн бүтээгдэхүүн болон үйлдвэрлэлийн гинжин хэлхээ бүхий барааг экспортлох нь дотоодын эрэлтийн дутагдлыг нөхөх, илүүдэл хүчин чадлыг ашиглах, ажил эрхлэлт ба орлогыг өсгөхөөс гадна хөгжингүй орнуудаас хараат байдлыг бууруулж, худалдааны маргааны эрсдэлийг сааруулах боломжтой гэж үзэж байна.³

1.2. Голлох түүхий эдүүдийн үнийн хэлбэлзэл өндөр байна.

Нүүрсний экспортын жилийн дундаж үнэ 2026 онд 70 \$/тн-д хүрэхээр байна.

Зураг 2. Нүүрсний жилийн үнэ, \$/тн



Эх сурвалж: Sxcoal, Mysteel

2025 оны эхний хагаст гангийн зах зээл болон аж үйлдвэрийн идэвх суларч, нүүрсний нөөц өссөнөөр Ганцмод боомт дахь коксжих нүүрсний үнэ 6 дугаар сард 700 юань/тоннд хүрч, сүүлийн 15 жилийн хамгийн доод түвшинд хүрэв. Харин 7 дугаар сараас үйлдвэрлэлийн хязгаарлалт болон байгаль орчны хяналт шалгалт эрчимжсэнээр олборлолт

буурч, үнэ 8 дугаар сарын 14-нд 995 юань/тоннд хүрч өссөн. Цаашид 2025 оны 8 дугаар сараас “276 ажлын өдөр” бодлого хэсэгчлэн хэрэгжиж эхлэхийн зэрэгцээ БНХАУ-ын ногоон эрчим хүч, дэвшилтэт өндөр технологи, био анагаах ухаан зэрэг салбарын хэрэгцээнд нийцсэн өндөр чанартай гангийн үйлдвэрлэл эрчимжих төлөв нь коксжих нүүрсний эрэлтийг дэмжиж, үнийг тогтвортой түвшинд хадгалах нөхцөл бүрдүүлэхээр байна.

² "Ерөнхийлөгч Ши Жиньпин БНХАУ-ын 15 дахь таван жилийн төлөвлөгөөний чиглэл, зорилтыг тодорхойлов"

³ "Өмнө чиглэсэн хөгжил: Барууны зах зээлээс цааш чиглэсэн БНХАУ-ын эдийн засгийн шинэ өсөлтийн стратеги"

Зэсийн үнэ өсөх төлөвтэй байна.


Зураг 3. Зэсийн үнэ, \$/тн



АНУ-ын ерөнхийлөгч Дональд Трамп 8 сарын 1-нээс хагас боловсруулсан зэс бүтээгдэхүүний импортод 50 хувийн тариф тогтоосон бол цэвэршүүлсэн зэсэд 2027 оноос 15 хувь, 2028 оноос 30 хувийн тариф тогтоох тухай мэдэгдсэн. Үүнтэй холбоотойгоор дэлхийн зэх зээлд богино хугацаанд зэсийн эрэлт нэмэгдэх бол нөгөө талаас Чили, Перу дахь томоохон уурхайнуудын доголдол нийлүүлэлтийг бууруулж ирэх онд зэсийн үнэ 9,700 ам.долларт хүрэх төлөвтэй байна.

Алтны үнэ тогтворжихоор байна.

Зураг 4. Алтны үнэ, \$/унц



Дэлхийн алтны зөвлөл(WGC)-ийн судалгаагаар, төв банкнууд сүүлийн гурван жил дараалан 1000 гаруй тонн алт нөөцөлсөн бөгөөд судалгаанд хамрагдсан нийт 73 төв банкнаас 95 хувь нь ирэх 12 сарын хугацаанд алтны нөөцөө өсгөнө гэж үзсэн нь эрэлтийг үргэлжлүүлэн нэмэгдүүлэх төлөвтэй байна. Мөн дэлхийн эдийн засгийн тодорхой бус байдал үргэлжилж байгаатай холбоотойгоор алтны үнэ 2,800 ам.долларт хүрч тогтворжих төлөвтэй байна.

Эх сурвалж: Блүүмберг терминал, ЭЗХЯ төсөөлөл


Төмрийн хүдэр болон газрын тосны хилийн үнэ бага зэрэг буурах төлөвтэй.

Зураг 5. Төмрийн хүдрийн хилийн үнэ*, \$/тн



БНХАУ-ын гангийн үйлдвэрлэл буурсантай холбоотойгоор төмрийн хүдрийн нөөц оны эцэст 27 сая тонноор өсөх төлөвтэй талаар Голдман Саксаас мэдэгдсэн байна. Мөн Австрали улс “Ногоон төмөр” үйлдвэрлэлийн стратегийн бодлогыг баримталж, төмрийн хүдрийн нийлүүлэлтээ өсгөснөөр 2026 онд үнэ 69 ам.долларт хүрч буурахаар байна.

Зураг 6. Газрын тосны үнэ, \$/бар




БНХАУ-ын эдийн засгийн идэвхжил суларч эрэлт буурахаар байгаа бол ОПЕК бүлэг болон Бразил, АНУ зэрэг орнууд нийлүүлэлтээ нэмэгдүүлэхээ зарласнаар үнэ 72 ам.долларт хүрэхээр байна. Нөгөөтээгүүр, Ойрх Дорнодын геополитикийн нөхцөл байдал хурцдаж Иран улс Хормузын хоолойг хаавал үнэ өсөх эрсдэл байгаа хэдий ч Голдман Сакс зэрэг байгууллагууд тус хоолойг хаах магадлал маш бага гэж үзэж байна.

Эх сурвалж: Блүүмберг терминал, *ГЕГ, ЭЗХЯ төсөөлөл,

1.3. Монгол Улсын эдийн засгийн төлөв байдал

Гадаад орчны эрсдэлтэй нөхцөл байдал үргэлжилж байгаа ч, ирэх онд Монгол улсын эдийн засаг 5.7 хувиар өсөж дунд хугацааны тогтвортой өсөлтийн түвшнийг хангахаар байна.

Гадаад худалдааны тэнцэл 2026 онд 3.2 тэрбум ам.долларын ашигтай гарч өмнөх оны түвшинд хадгалагдахаар байна.



Эх сурвалж: ГЕГ, ЭЗХЯ төсөөлөл

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2025 оны эхний 7 сард 14.2 тэрбум ам.долларт хүрч, худалдааны тэнцэл 1.3 тэрбум ам.долларын ашигтай гарлаа.


Экспортын орлого 2025 оны эхний 7 сарын байдлаар 7.8 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 16.3 хувиар буурсан байна. Үүнд, нүүрс, төмрийн хүдэр зэрэг голлох түүхий эдийн дэлхийн зах зээл дээрх үнийн бууралт

голлон нөлөөллөө. Оны үлдэх хугацаанд, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км хатуу хучилттай авто зам ашиглалтад орох, Тавантолгой-Ханги чиглэлийн төмөр замын тээвэр зохион байгуулалт сайжрах, Оюу толгойн гүний уурхайн зэсийн баяжмал дахь цэвэр зэс, алтны агуулга нэмэгдэх хүлээлттэй холбоотойгоор 2025 онд нийт экспортын орлого 15.8 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байна.

Цаашид, төмөр замын суурь дэд бүтэц сайжрах, Гашуунсухайт, Шивээхүрэн болон Ханги боомтын тээвэр зохион байгуулалт нэмэгдэх, зэсийн агууламж өсөх болон алтны олборлолтыг дэмжих арга хэмжээнүүдийн нөлөөгөөр 2026 онд нийт экспортын орлого 16.6 тэрбум ам.долларт хүрэхээр төсөөлж байна.

Импортын үнийн дүн 2025 оны эхний 7 сарын байдлаар 6.5 тэрбум ам.долларт хүрч, жилийн өсөлтийн хурд 1.1 хувьд хүрч саарлаа. Үүнд, хэрэглээний бүтээгдэхүүний импорт өмнөх оны мөн үеэс 14 хувиар өссөн бол аж үйлдвэрийн орцын импорт 10 хувиар, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 3 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Цаашид, эдийн засгийн өсөлт хадгалагдаж, хэрэглээний бүтээгдэхүүн болон үйлдвэрлэлийн завсрын хэрэглээнд ашиглагдах бүтээгдэхүүний импорт нэмэгдэх, томоохон төслүүдийн бүтээн байгуулалтын нөлөөгөөр барилгын материалын импорт өсөхөөр хүлээгдэж байгаатай холбоотойгоор 2025 онд импортын үнийн дүн 12.5 тэрбум ам.долларт, 2026 онд 13.4 тэрбум ам.долларт хүрэхээр төсөөлж байна.



Эх сурвалж: ҮСХ, ЭЗХЯ-ны төсөөлөл
*ҮСХ-ны сарын туршилтын тооцоо


Хөдөө аж ахуй, уул уурхай, аж үйлдвэрийн салбарын идэвхжилийн нөлөөгөөр энэ онд эдийн засаг 5.5 хувиар өсөхөөр хүлээгдэж байна. 2025 оны I улиралд уул уурхайн өсөлт удааширч, түүнийг дагасан тээвэр, худалдааны салбарууд уналттай гарснаар эдийн засгийн өсөлт 2.4 хувьд хүрч удааширсан. Харин хөдөө аж ахуйн салбар сэргэж, үйлчилгээ, аж үйлдвэрийн салбар тогтвортой өссөн нь эдийн засгийн өсөлтөд голлох эерэг нөлөөтэй байлаа. Оны сүүлийн

хагаст нүүрсний экспорт сайжирч, зэсийн экспорт өндөр түвшинд хадгалагдахын зэрэгцээ Баянхөндийн алтны төсөл олборлолтоо эхлүүлж алт олборлолт нэмэгдсэнээр уул уурхай, тээвэр, үйлчилгээний салбаруудын өсөлт сайжрах төлөвтэй байна. Түүнчлэн, хөдөө аж ахуй, уул уурхайн салбаруудын идэвхжил боловсруулах үйлдвэрлэлийг тэтгэхээр байна.

2026 онд уул уурхай, аж үйлдвэрийн салбарууд эрчимжиж эдийн засгийн өсөлт 5.7 хувьд хүрэхээр байна. Тухайлбал, Алт-3 хөтөлбөрийн хүрээнд шороон ордуудын олборлолт өсөхийн зэрэгцээ нүүрс, зэс, төмрийн хүдрийн олборлолт өндөр хэвээр хадгалагдаж уул уурхайн өсөлт 12 орчим хувьд хүрнэ. Хөдөө аж ахуйн салбарт Атар-4, Цагаан алт хөтөлбөрүүд хэрэгжиж үр тариа, хураасан ургац зэрэг анхдагч үйлдвэрлэл өсөхийн зэрэгцээ, мах, гурилын үйлдвэрлэл, ноос, ноолуурын боловсруулалт нэмэгдэж боловсруулах салбарын өсөлтийг дэмжинэ. Түүнчлэн, ирэх онуудад хэрэгжих томоохон төслүүд эдийн засгийн өсөлтийг дунд хугацаанд тогтвортой хадгалах хөшүүрэг болно. Тухайлбал, Эрдэнэбүрэнгийн УЦС, Газрын тос боловсруулах үйлдвэр, Дулааны III цахилгаан станцын өргөтгөл, Улаанбаатар-Шинэ Хархорум хот чиглэлийн автозамын өргөтгөл шинэчлэл, Зэс хайлуулах үйлдвэр, Гангийн үйлдвэр, Нүүрс-химийн цогцолбор, Туулын хурдны зам, Сэлбэ дэд төв зэрэг бүтээн байгуулалтын төслүүд барилга, боловсруулах салбарын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, өсөлтийг дэмжинэ.

Инфляц 2025 онд дунджаар төв банкны зорилтот түвшин орчимд байх төлөвтэй байна. Инфляц 2025 оны 7 дугаар сард 8.1 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 3.0 нэгж хувиар өслөө. Үүнд, мах, цахилгааны төлбөр, сургалтын төлбөр, орон сууцны түрээс, машин болон нийтийн тээврийн үйлчилгээ, хувцасны үнийн өсөлт голлон нөлөөлсөн байна. Төрийн зохицуулалттай үйлчилгээний үнийн өсөлтийн нөлөөгөөр дотоодын бараа, үйлчилгээний үнэ өсөх хандлагатай байсны зэрэгцээ эрэлтийн гаралтай инфляц өндөр байсан бол 2025 оны сүүлээс саарч, тогтворжих хүлээлттэй байна. Цаашид гадаад орчны эрсдэл, уур амьсгалын өөрчлөлт, тээвэр логистикийн саатлаас үүдэн инфляц өдөөгдөх эрсдэлүүд хадгалагдаж байна.

Зураг 9. Инфляцын түвшин, хувиар



Эх сурвалж: УСХ, ЭЗХЯ-ны төсөөлөл

2026 онд инфляц зорилтот түвшинд ойртох төлөвтэй байна.

Ирэх онд төрийн зохицуулалттай зарим үйлчилгээний үнийн өсөлтийн суурь үеийн нөлөө арилж, эрэлтийн шинжтэй инфляцын дарамт буурах хандлагатай байна. Засгийн газар “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөн болон хөдөө аж ахуйн тоног төхөөрөмжийг импортын тарифаас чөлөөлөх, үйлдвэрлэл, технологийн дэмжлэг үзүүлэх бодлогоо үргэлжлүүлсний

нөлөөгөөр хүнсний нийлүүлэлт нэмэгдэж, үнийн өсөлт саарах хүлээлттэй байна. Түүнчлэн, импортын гол боомт болох Замын-Үүд-Эрээн боомтод хийгдэж буй нарийн царигийн хил холболтын төмөр замын бүтээн байгуулалтын үр дүнд тус боомтын нэвтрүүлэлтийн хүчин чадал нэмэгдэж, барааны эргэлт сайжрах, нийлүүлэлтийн саатлаас үүдэлтэй үнийн өсөлт үүсэх эрсдэлийг бууруулахаар байна.

БҮЛЭГ 2. МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН БОДЛОГО

Дэлхийн томоохон гүрнүүдийн худалдааны дайн, геополитикийн хурцадмал байдал нэмэгдсэнээр тодорхой бус байдлын индекс 2008 оны санхүүгийн хямралаас хойш хамгийн өндөр түвшинд хүрээд байна.⁴ Гадаад орчны энэхүү нөхцөл байдлын улмаас экспортод түшиглэдэг болон уул уурхайн салбараас өндөр хамааралтай улсуудад экспорт саарч, төсвийн орлого буурах эрсдэлүүд бий болоод байна. Иймд улс орнууд зардлыг дахин хуваарилсан, дотоодын эдийн засгийг эрсдэлээс хамгаалах бодлого руу шилжиж эхэлжээ.

Жишээлбэл, Франц, Итали зэрэг Европын орнууд зардлаа танах, татвар нэмэх, төрийн зарим зардлыг хязгаарлах арга хэмжээ авч байгаа бол Австрали улсын хувьд төмрийн хүдэр, нүүрсний үнийн төсөөллөө өмнөх оны түвшинд авч, орлогын таамгийг хэт өсгөхөөс зайлсхийж байна. Мөн Аргентин, Бразил, Молдова зэрэг улсууд татаасыг бууруулах, халамжийг илүү зорилтот бүлэгт чиглүүлэх, тэтгэврийн тогтолцооны үр ашгийг нэмэгдүүлэх зэрэг санхүүгийн шинэчлэлийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулах бодлогыг эрчимжүүлээд байна. Үүнээс гадна геополитикийн эрсдэлээс үүдэн батлан хамгаалах зардал, эрчим хүч, шатахууны стратегийн нөөцийг нэмэгдүүлэх хандлагатай байна.

Монгол Улсад ч уул уурхайн салбарын өсөлт саарч, бүтээмж өндөртэй салбаруудад хөдөлмөр эрхлэлт буурч, өрхийн бодит орлого, хэрэглээ, худалдан авалтын идэвхжил суларч эхэллээ. Мөн гадаадын болон төсвийн хөрөнгө оруулалт буурч эдийн засгийн идэвхжил суларснаар эдийн засаг потенциал түвшиндээ хүрэхгүй байна.

⁴ Эх сурвалж: Дэлхийн тодорхой бус байдлын индекс (Индексийг Economist Intelligence Unit байгууллагаас гаргадаг улсуудын тайланд туссан "тодорхой бус байдал" гэсэн үгийн давтамжид үндэслэн тооцдог.)

Иймд 2026 оны төсвийн жилд эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулж хувийн хэвшилд суурилсан өсөлтийн загварыг дэмжих замаар макро тогтвортой байдлыг хадгална. Энэ хүрээнд иргэн төвтэй, бизнесийн орчныг дэмжсэн төсвийн бодлогыг хэрэгжүүлнэ. Мөн төсвийн зардлыг энэ оны түвшинд барьж, зардлын дахин хуваарилалт хийн иргэнд ээлтэй хүний хөгжлийг дэмжсэн бодлогыг хэрэгжүүлнэ.

2.1. БОДЛОГЫН 3 ЗОРИЛТ

1. Эдийн засгийн өсөлтийг дунд хугацаанд 5-6 хувьд хадгалж макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангана.

- Түүхий эдийн үнийн савлагаанаас шалтгаалан төсвийн орлого хязгаарлагдмал байгаа энэ үед хувийн хэвшил, гадаадын хөрөнгө оруулалт, гадаад бонд, зээлийн санхүүжилтийн эх үүсвэрээр эдийн засгийг дэмжинэ.
- Уул уурхайн салбарын үйл ажиллагааг эрчимжүүлж, бүтээмж болон хөрөнгө оруулалтын урсгалыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ уул уурхайн бус салбарын экспортын бүтэц, өрсөлдөх чадвар, зах зээлийн хүрээг өргөжүүлэх бодлого хэрэгжүүлж, эдийн засгийг төрөлжүүлнэ.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаад зээл тусламжийн санхүүжилтийг бодлогын тэргүүлэх салбар болох хүний хөгжил буюу боловсрол, эрүүл мэнд, мөн хувийн хэвшлийн бизнесийн орчныг сайжруулах суурь дэд бүтэц, түүн дотроо эрчим хүчний салбарт нэн тэргүүний төслүүдийг хэрэгжүүлэхэд чиглүүлнэ.

2. Төсвийн урсгал зардлыг 2025 оны түвшинд буюу ДНБ-ий 24 хувьд хязгаарлаж, Иргэн төвтэй-Хүний хөгжлийг дэмжсэн арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

- Нийгмийн суурь үйлчилгээ болох эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- Эмзэг бүлгийн орлогын баталгааг сайжруулах, хүн амын өсөлтийг дэмжих бодлогын хүрээнд нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- Иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, орлогод нийцсэн орон сууцны хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор орон сууцны зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн оновчтой зохицуулалт бүхий хөтөлбөр хэрэгжүүлнэ.

3. Эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулж, хувийн хэвшилд суурилсан өсөлтийг дэмжинэ.

- Төсвөөс санхүүжүүлдэг зарим чиг үүргийг хувийн хэвшилд шилжүүлж төсвийн урсгал зардлын өсөлтийг бууруулна.
- Иргэдийн орлогыг хамгаалах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, аж ахуйн нэгжүүдийн бизнесийн идэвхжилийг нэмэгдүүлэх татварын шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлнэ.

- Бизнес дэх төрийн оролцоог багасгаж, хувийн хэвшилд бизнес, хөрөнгө оруулалтын шинэ орон зай, боломжийг нээж өгнө.

2.2. БОДЛОГЫН 9 ЧИГЛЭЛ

1. Эдийн засгийг идэвхжүүлэх мөчлөг сөрсөн бодлого хэрэгжүүлнэ.

- Орлого төвлөрүүлдэг аймаг, нийслэл гадаад, дотоодын зах зээлээс бонд босгож эрчим хүч, дэд бүтэц зэрэг тулгамдаж буй асуудлаа шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- Орон сууцны төрөлжсөн банк байгуулж, зээлийн хүртээмжийг сайжруулах замаар барилга, үл хөдлөх салбарын үйлдвэрлэл, ажил эрхлэлтийг дэмжинэ.
- Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг хялбаршуулж, төр шаардлагатай зарим хөрөнгө оруулалтыг хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

2. Эдийн засаг болон экспортын төрөлжилтийг дэмжих бодлого хэрэгжүүлнэ.

- Гашуунсухайт боомтын хил холболтыг үргэлжлүүлж, Ханги, Шивээхүрэн боомтуудын хил холболтыг эхлүүлж тээврийн хүчин чадлыг нэмэгдүүлснээр нүүрсний экспортыг 90 сая тоннд хүргэнэ.
- Нэмүү өртөг шингэсэн уул, уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлж, үйлдвэрлэл технологийн паркуудын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ.
- “Малын эзэн-Үйлдвэрийн эзэн” арга хэмжээг хэрэгжүүлж, малын гаралтай түүхий эдийг дотооддоо боловсруулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд экспортолно.
- Ноос, ноолуур, арьс ширний бэлтгэл, үйлдвэрлэл, экспортыг дэмжих зорилгоор зээлийн хүүгийн дэмжлэг үзүүлж, ногоон зээл гаргаж буй зээлдэгчдийн тоог 10 хувиар нэмэгдүүлнэ.
- “Go Mongolia” арга хэмжээг үргэлжлүүлж, аялал жуулчлалын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар орлогыг нэмэгдүүлж, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

3. Эдийн засгийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, үйлдвэрлэл, худалдаа, логистикийн чадавхыг өргөжүүлснээр эдийн засгийн өсөлтийн суурийг бэхжүүлнэ.

- **Эрчим хүчний салбарт:** Хөрөнгө оруулалтын чиглэлээр нийт эх үүсвэрийн хүрээнд эрчим хүчний салбарт 3.7 их наяд төгрөгийн санхүүжилт хийгдэх бөгөөд Төв аймгийн Баян суманд 660 МВт хүчин чадалтай дулааны цахилгаан станц, Тавантолгойн 450 МВт-ын дулааны цахилгаан станц, Даланзадгадад 50 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц, Налайх Дулааны шинэ эх үүсвэр 79 МВт-ын станц, Эрдэнэбүрэнгийн 90 МВт усан цахилгаан станц, Чойр-Сайншанд, Бөөрөлжүүт-Сэргэлэн, Багануур-Чойр, Мандалговь-Арвайхээр чиглэлийн 220

кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц зэрэг эрчим хүчний том чадлын суурь горимд ажиллах эх үүсвэрийн төслүүд хэрэгжихээр байна.

- **Зам тээврийн салбарт:** Бүс нутаг хоорондын эдийн засгийн уялдаа холбоог сайжруулах, экспорт, импортын урсгалыг өргөжүүлэх, тээврийн зардлыг бууруулах боломжийг бүрдүүлэх зорилтын хүрээнд хөрөнгө оруулалтын чиглэлээр нийт 1.2 их наяд төгрөгийг санхүүжилт хийгдэх бөгөөд ингэснээр 551.3 км авто зам, 299.9 метр урт гүүр байнгын ашиглалтад орно.
- **Боомтын бүтээн байгуулалтад:** Хилийн боомтын төлөвлөлтийг хөрш орнуудтай уялдуулж, тээвэрлэлтийн олон төрөлт байдлыг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд Хавирга, Цагааннуур, Булган, Бичигт, Цагаандэл-Уул зэрэг боомтуудын өргөтгөл, шинэчлэлд нийт 51.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгоно. Үүний үр дүнд боомтын нэвтрүүлэх хүчин чадал 2-3 дахин нэмэгдэж, хил дамнасан тээвэр, логистикийн урсгал сайжирч, олон улсын худалдаа болон эдийн засгийн хамтын ажиллагаа өргөжнө.
- **Харилцаа холбоо:** Улсын төсөв, гадаад зээлийн хөрөнгөөр үүрэн холбооны сүлжээний өргөтгөл, шилэн кабель, 4G сүлжээний өргөтгөл зэрэг алслагдсан сум, баг, орон нутгийн иргэд өндөр хурдны интернэт болон мобайл сүлжээгээр хангах, мэдээлэл авах, боловсрол эзэмших, төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх боломжийг нэмэгдүүлэх, кибер аюулгүй байдлыг хангах, дижитал эдийн засгийг хөгжүүлэх, хөгжлийн индексийг дээшлүүлж, нийгмийн тэгш байдлыг дэмжиж, төрийн цахим үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлнэ. (56.6 тэрбум төгрөг)
- **Инженерийн дэд бүтэц:** Хотын хүртээмжтэй байдал, инженерийн дэд бүтцийн хангамжийг нэмэгдүүлэх замаар амьдралын чанарыг сайжруулах, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг хүртээмжтэй, өндөр чанартай болгох, иргэдийн аюулгүй байдал, амьдралын таатай орчныг бүрдүүлэх, түгжрэлийг бууруулах, дагуул хотуудын бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх, бэлтгэл ажлыг хангах чиглэлээр хөрөнгө оруулалтын төслүүдийг үргэлжлүүлнэ. (586.3 тэрбум төгрөг)
- **Онцгой байдал:** Дэвшилтэт технологи, инновацад суурилсан гамшгаас хамгаалах чадавхыг нэмэгдүүлэх, эрт сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг шуурхай авах, эрсдэлийг бууруулахад чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн төлөвлөлөө. Энэ хүрээнд техник, тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх, эрэн хайх, аврах нэгжийн хүчин чадлыг сайжруулах, гал түймэр унтраах тусгай зориулалтын техник хэрэгслийн бэлэн байдлыг хангахад 59.7 тэрбум төгрөг тусгалаа. Түүнчлэн, гадаад зээлийн хөрөнгөөр нийт 466.3 тэрбум төгрөгийн амлалтын дүн бүхий Монгол Улсын гамшгийн зарлан мэдээллийн нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх төсөл, Онцгой байдлын байгууллагын техник, тоног төхөөрөмжийг сайжруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх төслийг тус тус 2026 оноос эхлүүлж байна.

4. Эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 792.0 мянган төгрөг болж шинэчлэгдсэнтэй холбогдож нэмэгдэх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогын өсөлтийг

эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад зориулж хуваарилна. (82.5 тэрбум төгрөг)

- Эрүүл мэндийн даатгалын сангийн менежментийг тусламж үйлчилгээний санхүүжилтийн тогтвортой механизм болгоход чиглүүлж шинэчилнэ.
- Нэн шаардлагатайгаас бусад эмнэлгийн тусламж үйлчилгээний хамтын төлбөрийн хэмжээг зохистой байдлаар тогтоох замаар анхан шатлалаас лавлагаа шатлал руу шилжих урсгалыг сааруулах, хэвтүүлэн эмчлүүлэх шаардлагагүй тусламж үйлчилгээний тоог хязгаарлана.
- Эмийн төвлөрсөн худалдан авалтыг нэвтрүүлэх замаар хямд, чанартай эмийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- Эрүүл мэндийн байгууллагын чадавхыг сайжруулах, тусламж үйлчилгээг найдвартай хүргэх, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулах зорилгоор Хавдар судлалын Үндэсний төв-II барилга, Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төв, Зүрх, судасны үндэсний төв, Нийслэлийн хүүхдийн сэргээн засах "Эрүүл үрс" төвийн барилга зэрэг лавлагаа шатлалын эмнэлгүүд болон орон нутагт анхан болон дунд шатны эрүүл мэндийн төвүүдийн барилгын төслүүдийг шинээр хэрэгжүүлэх болон үргэлжлүүлэн хэрэгжүүлж ашиглалтад оруулахаар төлөвлөлөө. Мөн гадаад зээлийн хөрөнгөөр 17 аймгийн эмнэлгийн барилгыг шинэчлэх, эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулж, эрчимт эмчилгээ болон яаралтай тусламжийг сайжруулах төслийг 2026 онд эхлүүлж байна. (241.9 тэрбум төгрөг)
- Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг хүүхдэд ногдох хувьсах зардал, үдийн цай, дотуур байрын зардлыг боловсролд хамрагдах хүүхдийн тооны өсөлттэй уялдуулж нэмэгдүүлнэ (96.2 тэрбум төгрөг)
- Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардал хариуцагчийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор 2026 онд хоолны зардлын 50 хувийг эцэг эх хариуцдаг болно. Хоолны зардлыг эцэг, эхийн төлсөн хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлттэй уялдуулах замаар татварын суурийг нэмэгдүүлнэ. (69.5 тэрбум төгрөг)
- Сургуулийн өмнөх боловсролд бүх хүүхэд тэгш хамрагдаж, чанартай үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийн суурийг бий болгох боломжийг бүрдүүлж, энэ хүрээнд улсын хэмжээнд ээлжийн коэффициент 1.5-с дээш байгаа байршлуудыг их өгөгдөлд суурилан боловсруулсан нийт 95 цэцэрлэг шинээр барих тооцоололд үндэслэн эдгээрийг улсын төсөв, гадаад зээл тусламжийн хүрээнд 2026-2028 онд бүрэн ашиглалтад оруулах чиглэл баримталлаа. Төсвийн төсөлд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 46.7 тэрбум төгрөгийн санхүүжилт бүхий 30 цэцэрлэг, гадаад зээлийн санхүүжилтийн хүрээнд 11 цэцэрлэгийн барилгыг дуусгах, эхлүүлэхэд нийт 5.0 тэрбум төгрөгийг тусгав.
- Олон улсад өрсөлдөхүйц чанартай, тэгш хүртээмжтэй ерөнхий боловсролыг олгох боломжийг сайжруулах, энэ хүрээнд улсын хэмжээнд ээлжийн коэффициент 2.0-с дээш байгаа байршлуудыг их өгөгдөлд суурилан боловсруулсан нийт 108 сургууль шинээр барих тооцоололд үндэслэн эдгээрийг улсын төсөв, гадаад зээл тусламжийн хүрээнд 2026-2028 онд бүрэн ашиглалтад оруулах чиглэл баримталсан бөгөөд сургууль дүүргэлт зохистой түвшинд хүргэх,

ээлжийн коэффициентыг бууруулж, аймаг, сумын сургуулийн дэд бүтэц, сургалтын орчин, хэрэглэгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд 65 сургууль, 19 дотуур байрны барилгыг төлөвлөв. (243.1 тэрбум төгрөг)

- Боловсролын хүртээмж, чанарыг сайжруулах, олон улсын түвшинд нийцүүлэх зорилгоор ерөнхий боловсролын сургуулиудад байгалийн ухаан, технологийн хичээлийн лаборатори байгуулах, хоол үйлдвэрлэл, номын сан, урлагийн заалыг тохижуулах, дуу хөгжмийн хичээлийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хичээлийн хэрэглэгдэхүүн, сургуулиудын биеийн тамирын техник хэрэгсэл, цэвэрлэгээний тоног төхөөрөмжийг хангах, боловсролын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын онцлогт тохирсон хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийг сайжруулахад 48.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг улсын төсвөөс санхүүжүүлнэ. Мөн Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр нийт 9.3 тэрбум төгрөгийн сургууль, цэцэрлэгийн тоног төхөөрөмжийн санхүүжилтийг шийдвэрлэснээс гадна, 538.1 тэрбум төгрөгийн амлалтын дүн бүхий “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах” төслийн хоёрдугаар нэмэлт санхүүжилтийг 2026 онд эхлүүлж, боловсролын салбарын тогтвортой байдлыг хангах, чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байна.

5. Нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдийн хүртээмжийг сайжруулна.

- Нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг 6 хувиар нэмэгдүүлнэ (378.4 тэрбум төгрөг);
- Нийгмийн даатгалын болон халамжийн тогтолцооноос тэтгэвэр, тэтгэмж авах хүний тооны өсөлт, хүүхдийн мөнгөн тэтгэмжид хамрагдах хүүхдийн тооны өсөлт, түүнчлэн хөдөлмөрийн чадвар түр алдалт, ажилгүйдэл, оршуулгын тэтгэмжийн өсөлттэй уялдаж нэмэгдэх зардлын нөлөөллийг төсөвт тусгана;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн тэгш оролцоог хангах чиглэлээр буюу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тусгай хэрэгцээт хүүхдийн цэцэрлэг 2 болон Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн төрөлжсөн асрамжийн газрыг барьж дуусгах, тоног төхөөрөмжөөр хангах, мөн гадаад зээл, тусламжаар хэрэгжиж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төслийн хүрээнд Улаанбаатар, Архангай, Дархан-Уул, Дорнод, Дундговь, Завхан, Ховд, Хөвсгөл аймгуудад Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн барилга барьж ашиглалтад оруулснаар 30.0 мянган иргэнд тогтмол дэмжлэг үзүүлэх, 210 ажлын байрыг орон нутагт хангах боломжтой болно. (26.4 тэрбум төгрөг);

6. Орлогод нийцсэн орон сууцны санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлнэ.

- Орон сууцны санхүүжилтийн эрх зүйн орчныг бүрдүүлж, орлогод нийцсэн орон сууцны санхүүжилтийн банк байгуулна.

- Орон сууцны санхүүжилтийн банкны дүрмийн санг бүрдүүлэхэд шаардлагатай эх үүсвэрийг Монголбанкнаас үнэт цаас гаргах замаар бүрдүүлнэ.
- Орон сууцны зээлийн батлан даалтын тогтолцоог бий болгож, зорилтот бүлгийн зээлдэгч болон хөрөнгөөр баталгаажсан болон барьцаат үнэт цаасыг хамруулах, хүртээмжийг нэмэгдүүлж, эх үүсвэрийн зардлыг бууруулна.
- Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр орлогод нийцсэн орон сууцны санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх хүрээнд нийт 6,919 айлын гурван томоохон төсөл хэрэгжиж байна. (92.0 тэрбум төгрөг.)

7. Төсвөөс санхүүжүүлдэг зарим чиг үүргийг хувийн хэвшилд шилжүүлж төсвийн урсгал зардлын өсөлтийг бууруулна.

- Төрийн байгууллагын туслах үйл ажиллагаа (цэвэрлэгээ, харуул хамгаалалт, засвар үйлчилгээ, халаалт г.м), тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт, жижиг дунд үйлдвэрлэлийг болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагаа, ерөнхий боловсролын хоол үйлдвэрлэл, мэргэжлийн боловсрол сургалтын чиг үүргийг хувийн хэвشلээр гүйцэтгүүлэх (539.7 тэрбум төгрөг);
- Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг эцэг эх нь төлдөг тогтолцоонд гурван жилийн хугацаанд үе шаттай шилжүүлж санхүүгийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх (88.7-178.3 тэрбум төгрөг);

8. Эдийн засаг дахь төрийн оролцоог багасгах, иргэн, аж ахуйн нэгжийн татварын ачааллыг зохистой хэмжээнд шаталсан хэлбэрээр бууруулах, татварын тогтолцоо, бүртгэл, хамрагдалтыг сайжруулах, бүх нийтээр жигд шударга төлдөг татварын орчин бүрдүүлэх, хариуцлагатай татвар төлөгчдийг дэмжих татварын шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлнэ.

- Иргэдийн орлогын болон нэмэгдсэн өртгийн албан татварын хөнгөлөлтийг шаталсан хэлбэрээр үе шаттай нэмэгдүүлж иргэдийн татварын ачааллыг бууруулж, орлогыг хамгаалж дэмжлэг үзүүлнэ. Ингэснээр иргэд худалдан авалтын хэмжээнээс хамаарч 10%, 5%, 2%-ийн нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын шаталсан хөнгөлөлтийг эдлэх боломж бүрдэнэ. Үүний үр дүнд нийт цахим төлбөрийн баримтын 75 хүртэлх хувь 5 ба түүнээс дээш хувийн НӨАТ-ын хөнгөлөлт эдлэх шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлнэ.
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар ногдуулах босго, шатлалыг нэмэгдүүлж, жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд хялбаршуулсан бага татвар бүхий горимд хамрагдах боломжийг нэмэгдүүлнэ.
- Бүх нийтээрээ татварыг шударгаар төлдөг, үйлдвэрлэгчдэд дарамт учруулдаг олон төрлийн чөлөөлөлт, хязгаарлалтуудын өөрчлөн оновчтой болгон хариуцлагатай татвар төлөгчдийг дэмжих шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлнэ.
- Аж ахуйн нэгжүүдийн мөнгөн хөрөнгийн хомсдол, эргэлтийн хөрөнгийн дарамтыг бууруулах зорилгоор татвар төлөгчийн татварын хууль тогтоомжийн даган мөрдөлтийн түвшинд үндэслэн түүний дотоодын болон импортын

нэмэгдсэн өртгийн албан татвар төлөх хугацааг хойшлуулах, уян хатан төлөх боломжийг олгож дэмжлэг үзүүлнэ.

- Зөвлөн туслах үйлчилгээнд төвлөрсөн татвар, гаалийн байгууллагын тогтолцооны шинэчлэлийг эхлүүлж хийж, татварын эрсдэлд орохоос урьдчилан сэргийлж туслах, зөрчил гарсны дараа бус урьдчилан анхааруулж өөрөө сайн дураар засах боломжоор хангана.
- Татвар төлөгчийн хууль даган мөрдөлтийн түвшнийг үнэлж, хариуцлагатай татвар төлөгчдийн татвар төлөх хугацааг сунгаж уян хатан төлөх боломж олгох, дансыг бүрэн хаадаг зохицуулалтыг халж, тодорхой хэсгийг битүүмжлэн бизнесээ хэвийн үргэлжлүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

9. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг сайжруулж, бүтцийн өөрчлөлт хийнэ.

- Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хувьцааг олон нийтэд санал болгож, бүтцийн өөрчлөлт хийснээр 120 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг төсөвт төвлөрүүлнэ.
- Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн бүтэц, орон тоо, түүний цалин хөлсний бодлогыг оновчтой тогтоож, удирдлагын багийг улс төрөөс ангид, нээлттэй сонгон шалгаруулалт зохион байгуулан томилно.

БҮЛЭГ 3. МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ

Төсвийн төсөлд Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 31.6 их наяд төгрөг буюу ДНБ-ий 30.9 хувь, нийт зарлагын хэмжээг 33.0 их наяд төгрөг буюу 32.2 хувь, төсвийн суурь тэнцлийг 2.0 их наяд төгрөг буюу ДНБ-ий 2.0 хувьтай тэнцэх ашигтай байхаар төлөвлөлөө.

Хүснэгт 1. Нэгдсэн төсвийн үзүүлэлтүүд (тэрбум төгрөг)

ҮЗҮҮЛЭЛТ	2025 ТӨСӨВ	2026 ТӨСӨЛ	Зөрүү
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО	30,209.9	31,600.0	1,390.1
НИЙТ ЗАРЛАГА	31,573.9	32,980.0	1,406.1
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ	-1,364.0	-1,380.0	-16.0
ДНБ-д эзлэх хувь	-1.5	-1.3	0.2
СУУРЬ ЗАРЛАГА	28,400.5	29,553.0	1,152.5
ДНБ-д эзлэх хувь	31.6	28.7	-2.9
СУУРЬ ТЭНЦЭЛ	1,809.4	2,047.0	237.6
ДНБ-д эзлэх хувь	2.0	2.0	0.0

БҮЛЭГ 4. ТӨСВИЙН ЭРСДЭЛ

Төсөвт нөлөөлөх гадаад орчны эрсдэлийг голлох түүхий эдийн үнэ болон биет хэмжээний хэлбэлзэл, Засгийн газрын өрийн эрсдэлээр үнэлж, нөлөөллийг тооцсон бол дотоод хүчин зүйлсийг төрийн өмчит аж ахуйн нэгжийн эрсдэл, мөн байгалийн гамшиг, давагдашгүй хүчин зүйлийн нөлөөг зудын эрсдэлээр тооцооллоо.

1. Макро эдийн засгийн эрсдэл

Монгол Улсын эдийн засаг уул уурхайн салбараас өндөр хамааралтай, гадаад орчны эрсдэлд эмзэг болсон. Сүүлийн 20 жилд Монгол Улсын эдийн засгийн бүтэц уул уурхайн салбарт улам төвлөрч төсвийн орлогоо бүрдүүлж ирсэн. Тухайлбал, 2000-2009 онд уул уурхайн салбарын шууд болон шууд бус нөлөө⁵ нийт дотоодын нийт бүтээгдэхүүний дунджаар 21 хувийг эзэлж байсан бол сүүлийн таван жилд 30 хувьд хүрлээ. Энэ нь төсвийн нийт орлогын 30 орчим хувийг бүрдүүлж байна. Энэхүү бүтэц нь түүхий эдийн үнэ болон экспортын биет хэмжээний хэлбэлзэл, дэлхийн зах зээл дэх савлагаа, худалдааны түнш орнуудын эдийн засгийн идэвхжилд мэдрэг байдлыг нэмэгдүүлж байна.

Гадаад эдийн засгийн орчны тогтворгүй байдал манай улсын эдийн засагт түүхий эдийн зах зээлээр дамжиж нөлөөлж байна. Гадаад эдийн засгийн сорилт, тодорхой бус байдал дунд хугацаанд үргэлжлэх төлөвтэй байгааг ОУВС, Дэлхийн банк зэрэг олон улсын байгууллагуудын онцолж байна. Эдгээр хүчин зүйлс нь гол түнш орнуудын худалдааны тэнцэл, хөрөнгө оруулалтыг бууруулж, аж үйлдвэрийн салбарын өсөлтийг сааруулах бөгөөд Монгол улсын хувьд гол экспортын бүтээгдэхүүний үнэ, эрэлт болон валютын ханшаар дамжин төсвийн орлого, засгийн газрын өрийн тогтвортой байдалд эрсдэл үүсдэг байна.⁶ Иймд 2026 онд нүүрс, зэсийн үнэ буурах, нүүрсний экспортын биет хэмжээ буурах хувилбаруудаар мэдрэмжийн шинжилгээг хийж, экспортын орлого болон төсвийн орлогод үзүүлэх нөлөөг үнэллээ.

Шинжилгээний үр дүнд экспортын орлого болон төсвийн нийт орлогод хамгийн өндөр нөлөө үзүүлж буй хүчин зүйл нь нүүрсний биет хэмжээний бууралт байна. Тухайлбал, нүүрсний биет хэмжээ суурь төсөөллөөс 1 сая тонноор буурахад экспортын орлого ДНБ-ий 0.2 хувь, төсвийн тэнцвэржүүлсэн орлого ДНБ-ий 0.04 хувьтай тэнцэх хэмжээгээр буурахаар байна. Харин зэсийн үнэ 1 хувиар буурахад төсвийн орлого ДНБ-ий 0.01 хувиар буурах бол нүүрсний үнийн бууралтын нөлөө харьцангуй өндөр буюу ДНБ-ий 0.03 хувьтай тэнцэж байна.⁷

2. Төрийн өмчит аж ахуй нэгжүүдэд хийсэн эрсдэлийн шинжилгээ

Төсвийн эрсдэлийг макро эдийн засгийн түвшинд үнэлэхээс гадна салбар, байгууллагын түвшинд системтэй тодорхойлох нь чухал байдаг. Төрийн өмчит аж ахуй

⁵Тээвэр, худалдаа, боловсруулах салбар тус бүрийн хувьд уул уурхайн салбараас авч буй завсрын хэрэглээний нийт завсрын хэрэглээнд эзлэх жинг тооцоолж, эдгээр салбаруудын ДНБ-ийг тус жингээр үржүүлэн хооронд нь нэмж шууд бус нөлөөг тооцсон.

⁶ ОУВС "Article IV Consultations" 2025 оны 6 дугаар сар

⁷ Сангийн яамны урьдчилсан тооцоо

нэгж нь Монгол улсын эдийн засагт, ялангуяа уул уурхай, эрчим хүч, тээвэр зэрэг стратегийн салбаруудад чухал үүрэг гүйцэтгэдэг ба борлуулалтын орлогоос гадна нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгээ үзүүлэх, үндэсний хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх зэрэг хосолсон үүрэг хүлээдэг. Иймд манай улсын ТӨААН-ийн санхүүгийн эрсдэлийг үнэлэх нь Засгийн газарт өндөр эрсдэлтэй аж ахуй нэгжүүдийг тодорхойлж, хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд арга хэмжээ авахад үндэслэл болох юм.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны статистикийн мэдээгээр Монгол Улсад 9 өөр салбарт үйл ажиллагаа явуулж буй нийт 87 ТӨААН бүртгэлтэй байна. Үүнээс хөрөнгийн хэмжээ, ашигт ажиллагаа, мөнгөн хөрөнгө, өр төлбөрийн зохистой харьцааг харгалзан, санхүүгийн бус, ашгийн төлөөх хамгийн том 13 ТӨААН-ийг сонгон авч Олон Улсын Валютын Сангийн боловсруулсан ТӨААН-ийн санхүүгийн тогтвортой байдал, үйл ажиллагааны үр ашиг, төсөвт үзүүлэх эрсдэлийг үнэлдэг SOE Health check tool загварыг ашиглаж нарийвчилсан үнэлгээ хийлээ.

Шинжилгээний үр дүнд уул уурхайн бүтээгдэхүүнээ экспортолдог ТӨААН-ийн санхүүгийн эрсдэл доогуур, ашигт ажиллагаа өндөр байгаа бол дотоодын зах зээлд борлуулдаг ТӨААН-ийн үнийн зохицуулалтын нөлөөгөөр ашигт ажиллагаа, хөрвөх чадвар сул, эрсдэл өндөр байна. Санхүүгийн бус, ашгийн төлөөх ТӨААН-үүдийн хөрөнгийн өгөөж сүүлийн 5 жилд 0-ээс 9.6 хувь болж өссөн ч өсөлт нь цөөн уул уурхайн аж ахуйн нэгжид төвлөрсөн нь салбарын эмзэг байдлыг нэмэгдүүлжээ. Харин үйл ажиллагаа нь бүрэн эхлээгүй аж ахуйн нэгжүүд богино хугацаанд төсөв, санхүүгийн эрсдэл өндөр гарах төлөвтэй байна.⁸

3. Засгийн газрын өрийн эрсдэл

Засгийн газрын өрд учирч болох эрсдэлийг шууд болон шууд бус сувгаар ангилан авч үзэж, шаардлагатай тооцооллыг хийж гүйцэтгэлээ. Ингэхдээ шууд эрсдэлд ханшийн эрсдэл, хүүгийн эрсдэл, олон улсын зах зээлийн эрсдэл болон дахин санхүүжилтийн эрсдэлийг авч үзсэн бол шууд бус эрсдэлд засгийн газрын өрийн баталгаа, төрийн өмчит аж ахуйн нэгжийн өрийн эрсдэл болон орон нутгийн өрийн эрсдэлийг тус тус авч үзлээ.

Шинжилгээний үр дүнд Засгийн газрын өрийн зардал буурсан боловч эсрэгээрээ эрсдэл өсөж байгааг өрийн 96.3 хувийг гадаад өр эзэлж байгаа, нийт гадаад зээлийн 25 хувийг хөвөгч хүүтэй зээл эзэлж байгаагаас харж болно. Тухайлбал,

- **Ханшийн эрсдэл:** Валютын ханш 10 хувиар сулрахад Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь 4.1 хувиар, хүүгийн зардал 9 хувь буюу 120 орчим тэрбум төгрөгөөр өснө.
- **Хүүгийн эрсдэл:** Хөвөгч хүүтэй зээлийн хүү 1 хувиар өсөхөд хүүгийн зардал 60 орчим тэрбум төгрөгөөр нэмэгдэнэ.

⁸ ОУВС-ын SOE НСТ загварын эхний үр дүн

- **Олон улсын зах зээлийн эрсдэл:** Өрийн дахин санхүүжилт олон улсын хүү өсөлтөөс жилд 20 сая ам.долларын нэмэлт зардал дагуулна.⁹

Түүнчлэн, энэхүү улсын төсөвт шууд нөлөө үзүүлэх эрсдэлээс гадна шууд бусаар Засгийн газрын өрийн баталгаа, ТӨААН-ын өр төлбөр болон орон нутгийн өр төлбөр нөлөөлөхөөр байна. Энэхүү болзошгүй өр төлбөрүүд нь шууд улсын төсвөөс өрийн үйлчилгээ төлөгдөхгүй боловч баталгаа дуудагдах, ТӨААН өр төлбөрөө төлөх чадваргүй болох зэрэг хүчин зүйлсээс шалтгаалж улсын төсвөөс төлөгдөх, улсын төсвөөс дэмжлэг авах эрсдэлтэй байна.

4. Байгалийн гамшгийн эрсдэл: Зудын эрсдэл

Сүүлийн хоёр жилд зудын эрсдэлийн улмаас хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл буурч, эдийн засгийн өсөлт, хөдөлмөр эрхлэлт болон өрхийн орлогын түвшинд сөргөөр нөлөөлөв. Улмаар хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлт тасалдаж, инфляц нэмэгдэх зэрэг эдийн засаг, нийгэмд үзүүлэх сөрөг үр дагавар эрс нэмэгдсэн бөгөөд ийнхүү эрсдэлийн эдийн засаг, төсөвт үзүүлэх нөлөөг бууруулах бодлогын хариу арга хэмжээ шаардлагатай болсон.

Сүүлийн 25 жилд 2001-2003 он, 2009-2010 он, 2023-2024 онуудад нийтдээ 7 удаа зудын эрсдэл тохиолдож, дунджаар том малын зүй бус хорогдлын оны эхний нийт малд эзлэх хувь 10 хувьд хүрч энгийн жилүүдээс 8.0 нэгж хувиар өссөн бол бойжуулсан төлийн оны эхний нийт малд эзлэх хувь 27 орчим хувьд хүрч энгийн жилүүдээс 9 орчим нэгж хувиар буурсан байна.¹⁰ Ирэх онд зудын эрсдэл бий болсон тохиолдолд дээрх тооцооллоор малын хорогдол 6 орчим саяд, бойжуулсан төлийн тоо өмнөх жилээс 4.8 саяар буурах хувилбарыг тооцлоо. Шинжилгээний үр дүнд хөдөө аж ахуйн салбар 9.5 хувиар буурч, эдийн засгийн өсөлт 4.0 хувь болж суурь төсөөллөөс 1.7 нэгж хувиар буурахаар байна.¹¹

Мал аж ахуйн салбар нь зарим төрлийн татвараас чөлөөлөгддөг ба төсвийн орлогод шууд үзүүлэх нөлөө бага боловч зудын үед нөхөн сэргээх, хохирлыг бууруулахад ихээхэн зардал шаарддаг. Энэ зардлыг голчлон Засгийн газрын нөөц сангаас санхүүжүүлдэг бөгөөд 2023 онд уг сангийн 33 хувь (20.7 тэрбум төгрөг), 2024 онд 77 хувь (47.9 тэрбум төгрөг) нь өвөлжилтийн хүндрэл, зудын эрсдэлийг даван туулахад зарцуулжээ.

⁹ Сангийн яамны урьдчилсан тооцоо

¹⁰ Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

¹¹ Сангийн яамны урьдчилсан тооцоо

БҮЛЭГ 5. ТӨСВИЙН ТУСГАЙ ШААРДЛАГА

Монгол Улсын 2026 төсвийн үндсэн үзүүлэлтүүдийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан тусгай шаардлагад бүрэн нийцүүлж боловсрууллаа.

Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон байх: Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3.а-д заасан шаардлагын дагуу зэс, нүүрсний үнийг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон бөгөөд 2026 онд зэсийн тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 8,341.8 ам.доллар, нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 133.7 ам.доллар байхаар тооцлоо.

Нэгдсэн төсвийн суурь тэнцэл нь тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр буюу түүнээс дээш хувийн ашигтай байх: Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.2-т заасны дагуу нэгдсэн төсвийн суурь тэнцэл ДНБ-ий 2 хувиас дээш ашигтай байхаар төлөвлөлөө.

Хүснэгт 2. Нэгдсэн төсвийн суурь тэнцлийн ДНБ-д эзлэх хувь

	2026
Хуулийн хязгаар	2.0%
Төсөөлөл	2.0%

Тухайн жилийн нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувиас хэтрэхгүй байх: Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.3-т заасны дагуу урсгал зарлагыг ДНБ-ий 30.0 хувиас хэтрэхгүй байхаар төлөвлөлөө.

Хүснэгт 3. Нэгдсэн төсвийн урсгал зарлагын ДНБ-д эзлэх хувь

	2026
Хуулийн хязгаар	30.0%
Төсөөлөл	24.0%

Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх: Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т заасны дагуу Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдэл 2026 онд хуульд заасан хязгаарт байхаар байна.

Хүснэгт 4. Засгийн газрын өрийн төсөөлөл, нэрлэсэн дүнгээр (ДНБ-д эзлэх хувь)

	2026
Хуулийн хязгаар	60.0%
Төсөөлөл	43.5%